



**ЗАВХАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар 4410

Улиастай

**Аймгийн хэмжээний камержуулалтыг  
шалгаж, нэгдсэн дүгнэлт гаргах  
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.15 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд амар тайван орчин бүрдүүлэх, хүүхэд хамгааллын чиглэлээр орон нутагт тодорхой арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн эзэмшлийн зам, талбай болон байгууллага, аж ахуйн нэгжийн гадна, дотор талын камержуулалтад хяналт шалгалт хийж, ашиглалтад байгаа хяналтын камерын зураглалыг гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, засварлах, хэвийн ажиллагааг хангуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

**Ажлын хэсгийн**

|         |               |   |
|---------|---------------|---|
| ахлагч  | Н.Отгонжаргал | Завхан аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа    |
| Гишүүд: | У.Батдаваа    | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга     |
|         | Д.Бадамсүрэн  | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга   |
|         | Д.Анхтэс      | Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга        |
|         | Д.Бямбацогт   | Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга                        |
|         | Х.Онолбаатар  | Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга            |
|         | Ч.Наранбат    | Улиастай сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч                      |
|         | Д.Дамдинбазар | "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн Завхан аймгийн газрын дарга        |
|         | Г.Бадамхатан  | "Алтай-Улиастай Эрчим хүчний систем" ТӨХК-ийн Завхан салбарын захирал |

Захирамж-2023

311-3010961

П.Ганзориг  
Г.Амарсайхан

Э.Лувсанданзан

Нарийн бичгийн  
дарга: Г.Долгоржав

Аймгийн Автотээврийн төвийн дарга  
Аймгийн Гэмт хэргээс урьдчилан  
сэргийлэх ажлыг зохицуулах салбар  
зөвлөлийн нарийн бичгийн дарга  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө  
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт,  
хөрөнгө оруулалтын хэлтсийн Мэдээлэл,  
харилцаа холбооны хяналтын улсын  
байцаагч

2.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж Засаг даргад ажлын 7 хоногийн дотор тайлагнахыг ажлын хэсэг (Н.Отгонжаргал)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Н.Бямбадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ӨНӨРБАЯР

